

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
МОНГОЛ ХЭЛ СОЁЛЫН СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

Том. XXXI (328)

2010

193-197

**“МОНГОЛ АМАН ЗОХИОЛ СУДЛАЛААС
АРДЫН БИЛИГ ЗҮЙН ХҮН СУДЛАЛД”**

Г.Нандинбилиг¹

Өнөөдөр өрнөдийн нийгэмд, “folklorist” гэдэг үгийг аман зохиол судлаач гэж ойлгохоосоо илүү гудамж талбайд элдэв бүжиг дуу тоглож, үзүүлбэр үзүүлж, мөнгө олдог хүн гэсэн сөрөг утгаар ойлгох хандлага бий болж, улмаар аман зохиол судлаачдыг угсаатан судлаач, хүн судлаачдаас төдийлон ялгаж үзэхээ больсон байдалтай болжээ. “Folklorist” гэдэг үгийн энэхүү утгын хувирлаас үүдээд бид энэ удаад тус шинжлэх ухааны жинхэнэ судлах зүйл, зааг хязгаарын талаар дахин бодолхийлж, дэлхий дахинь ардын билиг зүй, хүн судлал (anthropology) - угсаатан судлал (ethnology)-ын хамгийн сүүл үеийн хувьсал өөрчлөлт хийгээд монгол аман зохиол судлалын өнөөгийн чиг хандлагын талаар хөндөн эргэцүүлэхийг зорьсон юм.

Асуудлыг нухацтай авч үзэхийн тулд юуны өмнө нэр томьёоныхоо анхны утгад эргэн очиж бодолхийлэх нь нэн чухал билээ. Өдгөө бидний “аман зохиол” гэж нэрлэн заншсан, өмнө хугацаанд Европын орнуудад янз бүрээр нэрлэж байсан уг судлагдахууныг 1846 онд Их Британийн судлаач У.Томс саксон хэлний “folklore” гэдэг үгээр ялган нэрлэхийг санал болгож, тэр цагаас хойш энэ даруухан үг Их Британи болон түүний колони орнууд, улмаар дэлхий дахинд нэр томьёо болон дэлгэрснийг бид мэднэ. Харин нэр томьёоны анхны утга нь амаар зохиогдсон уран зохиол гэхээсээ илүүтэй ардын уламжлалт зан зүйл, аман уламжлалт мэдлэгийг нэрлэж байсан гэдгийг тэр бүр мэддэггүй. У.Томсын анхлан тодорхойлсноор “энэ бол хүний далд ухамсын үр шим, домгийн сэтгэлгээний мөн чанар бүхий мэдлэг мөн” билээ. Тэрээр “энэ бол уран зохиол гэхээсээ илүү ардын мэдлэг ухааныг заан нэрлэж байгаа учраас “ардын билиг ухаан” гэсэн утга бүхий саксон хэлний “folklore” гэдэг үгээр ялган нэрлэх нь илүү зохимжтой юм” гэсэн саналыг дэвшүүлжээ.

“Folklore” хэмээх энэ үг нь хэдийгээр нэр томьёо болон хэвшсэн хэдий ч тус ухааны судлах зүйлд чухам юу юуг хамааруулах тухайд дэлхийн олон улс үндэстнүүд адил бус үзэл хандлагатай явж иржээ. “Folklore” гэдэгт ардын уран зохиол, үгийн урлагийн зүйл, ардын ёс заншил, шүтлэг мөргөл, эд өлгийн соёл хийгээд бүхий л уламжлалын зүйлсийг хамтад нь багтаан ойлгох хандлага өрнө дахинь шинжлэх ухаанд нийтлэг бол Оросын шинжлэх ухааны шууд нөлөөгөөр хөгжсөн манай аман зохиол судлал бол зөвхөн амаар дамжиж ирсэн ардын уран зохиолын зүйлсийг л ялган судалж ирсэн байдаг. Товчхон хэлбэл, “folklore” хэмээх үг нь олон улсад нэр томьёо болон дэлгэрэхдээ анхны утга нь зарим талаар алдагдаж, өргөн явцуу хоёр утгаар хэрэглэгдэж ирсэн байна. Энэ нь тухайн ард түмний соёл иргэншлийн хэв маягаас багагүй хамааралтай

¹ Доктор. МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

билээ. Уламжлалт аман соёлын зүйлс нь сонгодог соёлдоо дарагдан мартагдахад хүрсэн суурин соёл иргэншилт Европын улс үндэстнүүдийн хувьд аман зохиол судлал бол харьцангуй хожуу үүссэн шинжлэх ухаан учраас ардын үгийн урлагийн бүтээлээс гадна уламжлалт соёл, ёс заншил зэргийг багтаасан өргөн утгаар хамаарч судлах нь бас ч зүйн хэрэг билээ. Харин аман зохиолын зүйлс нь харьцангуй хадгалагдан үлдсэн, нүүдлийн соёл иргэншил нь өнөөдөр ч хэвээр бүхий манай үндэстний хувьд бол аман зохиол судлал чухам цаг үеэ олж үүссэн бөгөөд Оросын хэл шинжлэл, утга зохиол судлалын нөлөөгөөр зөвхөн ард түмний дунд амаар зохиогдсон үгийн урлагийн зүйлсийг л ялган судалж иржээ.

Аман зохиол судлалын үүсэл бол уран зохиол судлалын нөлөөнөөс гадна хүн судлал - угсаатан судлалтай салшгүй холбоотой. Шинжлэх ухаан үүссэн цагаас ямагт харь соёлыг сонирхон судалж ирсэн өрнөдийнхний хувьд өөрийн орны эртний ёс уламжлал, ардын уран зохиолыг сонирхон судлах нөхцөл шаардлага бий болсноор судлагдахууны ялгаатай нөхцөл байдал үүсч, энэхүү ялгааг тэд **өөрсдөөсөө харь соёлыг судалбал хүн судлал (anthropology) болно, өөрсдийн уламжлалт соёлоо судалбал аман зохиол судлал (folklore) болно** гэж ойлгож ухаарч ирсэн байдаг. Энэ бол уг судлагдахуун нь орон зайн хувьд алс байх шаардлагатай гэсэн үзэл бөгөөд хүн судлалын ухаан бүхэл дөрвөн зууны туршид энэ гол үндэслэл шаардлагаа баримталж² ирсэн ба өрнөдийн ардын билиг зүй буюу биднийхээр аман зохиол судлалын шинжлэх ухааны үндэслэлүүд нь :

- хүн амын зөвхөн нэгэн давхрааны соёл, тухайлбал **тариачны соёлыг** л судлах,
- шинжлэх ухааны судлагдахуун нь **эдийн болон оюуны соёл** хоёулаа байх,
- шинжлэх ухааны судлагдахуун нь тухайлсан нэг үндэстний тариачид, ихэнх тохиолдолд **судлаачийн өөрийнх нь хамарагдах үндэстний тариачны соёлыг** судлахад оршиж байсан билээ.

Хүн судлал - угсаатан судлал, ардын билиг судлалын ялгарч хөгжсөн түүх ийм байгаа ч хүн судлал, угсаатан судлалын дэг сургуулиуд орон орноороо ялгаатай байсан гэж болно. Угсаатан судлал, хүн судлалын загваруудаас ардын билиг зүйд хамгийн ээлтэй нь Францын загвар гэж хэлж болох бөгөөд эртний домгийн бүтцийн задлан шинжлэлийг шинжлэх ухаанд авчирсан билээ³. Франц орон харь этгээд нийгмийг

² Францын эрдэмтэн Клод Леви-Стросс (Claude Levi-Strauss) нь “алсалмал хараа” буюу судлаач судлагдахуун хоёр орон зайн ялгаатай байх ёстой тухай өгүүлсэн.

Шинжлэх ухаанд, судлаач нь судлагдахуунаасаа ялгарч байхыг чухалчилдаг. Зарим шинжлэх ухаанд судлаач судлагдахуун хоёр нь эрс ялгарч чаддаг. Түүхийн шинжлэх ухааны судлагдахуун нь судлаачаасаа цаг хугацааны алслалд оршдог бол угсаатан судлал - хүн судлалын хувьд бол гол ялгаа нь газар зүйн байрлал, орон зайн алслал байдаг. Тухайн угсаатны хүнд ажиглагдахгүй байж болох олон зүйлс гадны хүний нүдэнд содон байдаг. Энэ “гаднын нүд” бол судлаачийн хараа болно. Өөрөөр хэлбэл, газар зүйн алслал гэдэг бол соёлын алслал бөгөөд энэхүү алслалаас гарч ирэх онцгой содон өкзөтийлбэрийн байдал нь харь соёлыг мэдрүүлдэг. Иймээс XVIII зуунд шинжлэх ухааны материалыа аль болох алс холоос олж ирэхийг зорьдог байсан. Тэгвэл аман зохиол судлалд энэ ялгаа ямар байна вэ? Ахь харахад аман зохиол судлаачид бол аман зохиолыг бүтээгчидтэйгээ нэгэн цаг үед, нэгэн орон зайд ажиллаж буй мэт харагддаг. Гэхдээ үнэндээ бол аман зохиол судлаачид бол ямар нэг хэмжээгээр судлагдахуунаасаа цаг хугацааны алслалд байдаг.

³ Францын этнологид хээрийн шинжилгээг жинхэнэ утгаар хөгжүүлсэн хүн болох Марсель Гриоул (Marcel Griaule) (1898-1956) бол францын бэлгэдлийн хүн судлалыг үндэслэгч гэж болно. Тэрээр Малид байдаг догончуудыг сонгон, 1947 он хүртэл Малид сууж хээрийн шинжилгээ

сонирхохын зэрэгцээгээр ийнхүү ардын билиг зүйн нөлөөнд автаж байсан бол Британичууд өөрсдийн түүхийн олон янз байдлыг ахин танин мэдэхээс татгалзаж байлаа. Харин колонийн уламжлалгүй орнууд (Умард болон Зүүн Европын орнууд) эхлээд ардын билиг зүйгээр хөөцөлдөж байснаа 1970-аад оны онолын томоохон өөрчлөлтийн дараагаар угсаатан судлалын чанартай дахин бүрдүүлэлт хийж эхэлсэн байдал.

Аман зохиол судлал өрнө дахинд анх үүсэхдээ аман зохиолын нийгмийн үүргийг чухалчилж, угсаатан судлал буюу хүн судлалын шинжлэх ухааны шууд нөлөөн доор уран зохиол судлагчдын дэмжлэгтэйгээр үүссэн түүхтэй. Чухамхүү аман зохиолын нийгмийн үүргийг чухалчлах энэ хандлага нь өдгөө түүнийг уран зохиол судлалын хүрээнээс халин угсаатан судлал, хүн судлалтай эргэн төрхөмсөхөд хүргэж байж болох ч аливаа шинжлэх ухааны түүхэнд ялгаран салж хөгжсөн нэгэн үе байхад эргэн төрхөмсөх өөр нэгэн цаг үе байдаг гэлтэй. Өнөөдөр дэлхий дэхинд шинжлэх ухаануудын төрхөмсөл гэж болох өвөрмөц содон үзэгдэл өрнөж байна. Тодруулж хэлбэл, шинжлэх ухааны арга зүйд Францын угсаатны судлаач Леви Стросс⁴-ын нөлөөгөөр “Соёлын хүн судлал” (Cultural anthropology) гэдэг нэр томьёо үүсч, хэвшиг төлөвтэй байгаа ба энэ нь хүний нийгмийн бүтэц байгууламж, хэл, хууль, улс төр, шашин, домын төсөөлөл, урлаг, угсаатны зүйг тусгайлан судалдаг хүний соёлын шинжлэх ухааныг заан нэрлэж, үүний дотор бидний “аман зохиол” гэж нэрлэж заншсан судлагдахуун ч хамаарч байна.

Өрнөдийн нийгэмд ардын билиг зүйч буюу аман зохиол судлаач гэсэн мэргэжил бараг мартагдаж гээгдэх байдалтай буюу угсаатан судлаач, хүн судлаачдаас төдийлэн ялгаж үзэхээ больсон байдалтай байгаагийн цаад учир нь бидний бодлоор хоёр талтай. Нэг талаас ардын билиг уламжлал нь сонгодог соёлдоо дарагдсан өрнөдийн угсаатнуудын хувьд ахин дахин судлаад байх аман зохиол гэх юм бараг үгүй болсны зэрэгцээ зөвхөн бичигт тэмдэглэгдсэн баримтад л итгэх арга зүйн гэмээр алдааны улмаас ийм байдалд хүрсэн байна. Нөгөө талаас улам бүр мэдлэг чадвартай орон нутгийн хамтрагчид буй болж, угсаатан судлаачид, хүн судлаачдын судалж байсан “Бусад” нь эргээд үгүйсгэх аргагүй боловсролтой угсаатан судлаачид болчихсон явдал нь угсаатан судлалыг эргэлзээтэй болгож байна.

Хүн судлал, угсаатан судлал өдгөө түгээмэл шинжийг олж, өөрийнхөө нийгмийг судлах боломжийг бүрдүүлжээ. Угсаатан судлаачдын сонирхдог байсан харь этгээд “баларлаг нийгэм”, “баларлаг соёл” аль хэдийн сонгодог утгаараа үгүй болж, даяаршлын эрин үед угсаатан судлал, хүн судлалын сонирхох сэдэв нь өнөөгийн нийгэм, нийгмийн өөрчлөлт, өдгөөчлөл, хотжил, өрнөшил, цагаачдын соёл, соёл хайлах үзэгдэл зэрэг өөр сэдэв болон дахин хувирчээ. Ингэхлээр **Бусад** гэдэг нь гагц баларлаг, сонин хачин, этгээд юм төдий биш, бидний хөдөөх өвөг дээдэс төдий биш, харин бидэнтэй хамт

хийсэн байна. Тэгээд алдарт “Усны тэнгэр” буюу “Ogotemeli-тэй ярилцсан нь” хэмээх бүтээлээ бичсэн аж. Энэ ном бол бүхэлдээ Оготемели гэдэг нэгэн өвгөн анчintтай харилцан ярилцсан яриа болно. Ярилцлагыг тэр чигээр нь буулгасан нь угсаатны зүйн материалыг ярилцлагын хэлбэрээр бичих бичлэгийн шинэ арга болсон гэдэг. Энэ бүтээл одоо ч бэстсэллэр болсоор байна. Марсел Гриол бэлгэдэл зүй, домог зүйгээр дамжуулж догончуудын хамгийн үнэ цэнэтэй ертөнцөд нэвтрэхийг зорьсон байна. Догончуудын одон ертөнцийн тухай төсөөлөл гэдэг бол ганц өвгөн анчин дээр судалгаа хийсэн ч гэсэн догончуудыг бүхэлд нь судалсан, домог зүйгээс нь одон ертөнцийг судалсан судалгаа юм. М.Гриолын судалгааг бэлгэдэл зүйн судалгаа ч гэж нэрлэдэг.

⁴ Levi-Strauss Cl. Anthropologie structurale. Paris, Plon, 1958

оршин аж төрж буй манай нийгмийн бүтээл болсон Бусдын хамтлаг (цагаачид, дүрвэгсэд г.м.) юм (Ж.Копан 2007, 52) хэмээн ухаарч эхэлжээ. Хүн судлал хэт онолчирхлоос ангижирч, ялангуяа Францын этнологид бол соёлын өвөө судлан шинжлэх нь үнэ цэнтэй болж, нэг угээр хэлэхэд орчин үеийн судалгааг орхин, түүхэн хүн судлалыг (*anthropologie historique*) илүү чухаллах хандлагатай болж байна. Өrnөдийн хүн судлал, угсаатан судлалын өнөөгийн байдлыг хэлэхэд өөрийн шинжлэх ухааны судлагдахуунаа дахин тодорхойлж, алсалмал харааг оролцогчийн хараа залгамжилж байгаа бөгөөд “нийгмийн шинжлэх ухааны бусад судлагдахууны судлах зүйлсийг салган зааглаж буй газар зүйн болон сэдэв зүйн хил хязгаарыг арчин арилгахад бэлэн бүрэн дүүрэн цоо шинээр дахин зохицох үйл явцын дунд байна” (Ж.Копан, 2007, 52). Энэ бүхий байдал нь хүн судлал, угсаатан судлалын шинжлэх ухааны аливаа ялгарааны, аливаа алслалын тухай дөрвөн зууныг туулсан үзэл онолыг ч эргэлзээнд оруулж байгаа бөгөөд “Folklorist” гэдэг үгийн утгын хувирлыг ч мөн үүгээр тайлбарлаж болно. Чухам энэ утгаар, аман зохиол судлаач бол харь соёлыг бус өөрийн соёлыг судалж буй угсаатан судлаач, хүн судлаач мөн бөгөөд хамгийн зөвөөр хэлбэл соёлын хүн судлаач, ардын билиг зүйн хүн судлаач (*ethnologie folkloristique*) мөн билээ. Яг ийм төлөв хандлагаар манай орны аман зохиол судлалын шинэ хандлагыг тайлбарлаж болно.

Өнөөг хүртэл монгол аман зохиол судлал маань судалгааны хоёр талбарт ажиллаж байсны нэг нь уран зохиол судлалын “томилот”, нөгөө нь шүтлэг мөргөл, домог зүй, бэлгэдэл зүйн хүн судлал байсан гэж болно. Оросын хэл шинжлэлчид, утга зохиол шүүмжлэгчдийн нөлөө бүхий аман зохиол судлал хөгжиж байсныг бид бүгд мэднэ. Харин 1980-аад оноос Францын этнологиор дамжин, өrnөдийн ардын билиг зүй, угсаатан судлалтай танилцсан ба үнэндээ сүүлийн хорь гаруй жилийн турш Монгол улсад монгол аман зохиолын судалгаа нэрийн доор домог зүй, бэлгэдэл зүйн хүн судлал хөгжиж байна.

Ийнхүү монгол аман зохиол судлал зүгээр нэг сэдэв судлагдахууны тулгамдсан асуудал төдий биш, дэлхий дахины ардын билиг зүй, угсаатан судлалын хамгийн сүүл үеийн хувьсал өөрчлөлтийн давалгаан дунд хамт нэгэн үелэлд багтаж буй асуудлуудыг хөндөж байна. Шинжлэх ухааны жинхэнэ судлах зүйл, зааг хязгаарын талаар дахин бодолхийлж буй монголын аман зохиол судлалын энэ түүхэн үе бол монгол аман зохиол судлалын хүн судлал, угсаатан судлалын ухаанд төрхөмсөх үйл явц төдий бус дэлхийн судалгаатай хөл нийлэн алхах гэсэн шинэчлэл болох юм.

Зүүлтийн ном зүй

1. Dictionnaire de l'ethnologie et de l'anthropologie. Publié sous la direction de Pierre Bonte, Michel Izard, Press Universitaires de France, 1991, 755 p.
2. Levi -Strauss Claude. Anthropologie structurale. Paris, Plon, 1958
3. Levi-Strauss Claude. Le regard йлоигий. Paris, Plon, 1983, 398 p.
4. Griaul Marcel. Dieu d'eau: Entretiens avec Ogotemmeli. Fayard, 1966, 234 p.
5. Копан Ж. Угсаатан судлал, хүн судлалын удиртгал. Франц хэлнээс орчуулсан С.Дулам, хянан тохиолдуулсан Т.Төмөрхүлэг, Д.Бум-Очир, Улаанбаатар, 2007, 141 т.х.

SUMMARY

In this article, the author discusses the contemporary tendency on Mongolian folklore, and most recent development of the world folklore, anthropology and ethnology. It needs to re-think that what we should study in the frame of folklore.

For westerners, they followed the discipline for 400 years that researchers should be distant from their objectives of anthropology and ethnology but today this has been considering by different aspects. By this, the folklorist will be a cultural anthropologist or folkloric ethnologist, who is studying his own culture.

Traditional Mongolian folklore focused on two different parts: the first part is followed by the influence of Russian linguistic and literary study; the other part is the influence of western including ethnology in France. In fact, symbolic anthropology and cultural anthropology in Mongolia have been developing under the name of the Mongolian folkloric study for the last twenty years.